



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2021 оны 5 сарын 20 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Аймгийн сонгуулийн хорооны  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Архангай аймгийн сонгуулийн хорооноос ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 01/1164 дүгээр албан бичгийг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Архангай аймгийн сонгуулийн хорооны гишүүнээс Цогтгэрэлийн Жавхлант, Говь-Алтай аймгийн сонгуулийн хорооны гишүүнээс Галсандоржийн Ууганбаатар, Цолмонгийн Эрдэнэбатыг чөлөөлсүгэй.

2. Архангай аймгийн сонгуулийн хорооны гишүүнээр Галсанцэрэнгийн Галсандорж, Говь-Алтай аймгийн сонгуулийн хорооны гишүүнээр Даржаагийн Баттайван, Чулгын Батцэцэг нарыг томилсугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000119